

БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

20.... оны дугаар сарын-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот.

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 246 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын нэгдүгээр хавсралтыг энэ тушаалын хавсралтаар өөрчилсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 246 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дөрөвдүгээр хавсралтын 6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 246 дугаар хоёрдугаар хавсралтаар баталсан “Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”-ын дөрөвдүгээр хавсралтын 6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Х.БАДЕЛХАН

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН СУУРЬ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Д/д	Заалт	Эрхлэх үйл ажиллагаа	Инженер техникийн үндсэн ажилтан	Аж ахуйн нэгжийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, программ хангамж
4	Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	-Геодези, зураг зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа /4.1.3-аас бусад/	Геодезийн инженер – 2 Геодезийн инженерийн аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байна.	1. Электрон тахеометр -1ш / $\leq 2''$ / 2. GNSS-ийн хүлээн авагч -2ш 3. Өндрийн хэмжилтийн багаж -1ш / $\leq \pm 1.5\text{мм}$ / 4. Геодезийн хэмжилт зураглалын ажилд баримтлах норм дүрэм, заавар, гарын авлага
5	Зурагзүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	ГЗЗТХ-ийн 4.1.3-д заасан үйл ажиллагаа	Мэргэшсэн зураг зүйн инженер – 1	1. Зураг зүйн ажилд баримтлах норм дүрэм, заавар, гарын авлага 2. Плоттер -1ш